

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД
ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ,
ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА

АУДИТЫН НЭР: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ



АУДИТЫН КОД:
ЗАА-2023/30-12-ШТА-НА

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа
Утас: 7046-3612, Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn
Аудитын менежер Б.Дагвасүрэн
Утас: 7046-3783, Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Заяа
Утас: 92988288, Цахим хаяг: zayag@audit.gov.mn
Аудитор Б.Мөнхнасан
Утас: 90066888
Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn
Аудитор Т.Баасанжаргал
Утас: 92012266
Аудитор Г.Баасанжаргал
Утас: 99032514
Цахим хаяг: baasanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас www.audit.mn

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	2
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....	3
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.	4-10
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.	10-16
БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ, НӨХЦӨЛ БАЙДАЛД ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭГ АВААГҮЙ БАЙНА.....	17-19
ДҮГНЭЛТ	20-21
ЗӨВЛӨМЖ:	22-23
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	24-26
АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ	27

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНАТ	Байгалийн нөөц ашигласны төлбөр
БНСАХ	Байгалийг нөхөн сэргээх арга хэмжээ
БОАЖ	Байгаль орчин аялал жуулчлал
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БОАЖС	Байгаль орчин аялал жуулчлалын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХААУГ	Хөдөө аж ахуйн удирдах газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт арга зүй
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаал зэргийг үндэслэн хийлээ.
Аудитын зорилт	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг ҮАГ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • <i>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх.</i> • <i>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт, зарцуулалт хууль, журмын дагуу хэрэгжсэн эсэх.</i> • <i>Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийн, нөхцөл байдалд тохирох арга хэмжээ авсан эсэх.</i>
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, аймгийн Татварын хэлтэс, Усны сав газрын захиргаа, Сум дундын ойн ангиудын 2021-2023 оны үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020, MNS 6817-8:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан хийсэн. Ингэхдээ аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.
Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа, аудитын менежер Б.Дагвасүрэн нар хянан удирдаж, ахлах аудитор Г.Заяа, аудитор Б.Мөнхнасан, аудитор Т.Баасанжаргал, аудитор Г.Баасанжаргал нар 2023 оны 05 дугаар сарын 19-ээс эхлэн 2023 оны 06 дугаар сарын 19-ний хооронд хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ А. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ШААРДЛАГЫН ХЭМЖЭЭНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.

А.1. Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт ногоон хөгжлийн талаар дэвшүүлсэн арга хэмжээний хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

А.1.1 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь 4 хууль тогтоомж, бусад эрх зүйн 2 актын зүйл заалттай нийцэхгүй байна.

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Ургамлын тухай хууль, Ойн тухай хуулийн зарим заалтууд хоорондоо уялдахгүй байна. Тухайлбал: Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т “Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан төлбөр тооцох үзүүлэлт дэх экологи-эдийн засгийн үнэлгээгээр нэн ховор ургамлыг 25-30%, ховор 15-20%, элбэг 5-10 хувиар тооцно”, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1-д “элбэг ургамлыг ахуйн хэрэгцээнд ашигласан иргэнийг төлбөрөөс чөлөөлнө”, Ойн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан БОАЖС-ын 2022.08.09-ний өдрийн А/290 тоот тушаалын дагуу төлбөрийн бичилт хийж байгаа зэргээс харахад тухайн хуулиудын заалтууд хоорондоо нийцэхгүй байгааг харуулж байна. Иймд Ургамлын тухай хууль болон Ойн тухай хуулийн уялдаа холбоог сайжруулж ойд ургаж буй жимсийг ойн дагалт баялаг эсвэл байгалийн ургамлын аль төрөлд оруулж төлбөр хураамжийг тооцох вэ гэдгийг тогтоож холбогдох хуулиудад өөрчлөлт оруулж шийдвэрлэх шаардлагатай байна.
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан усны шоо метр тутамд доод дээд төлбөрийн хязгаарыг тогтооно" гэсэн нь мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д "хүн амын унд, ахуйн хэрэгцээнд болон бэлчээрийн мал, амьтан, өрхийн хүнсний ногооны талбайг услах зориулалтаар ашигласан төлбөр төлөгчийг төлбөрөөс чөлөөлнө" гэсэнтэй нийцэхгүй байна.
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.1-д “Сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөр хураах эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулна” гэсэн заалт байгаагаас аймгийн Байгаль орчны газраас тайлан, мэдээ, судалгаа шаардахад хариуг ирүүлдэггүй, сумын байгаль орчин хариуцсан байцаагч нар уг асуудалд хариуцлагагүй ханддаг. Иймд энэ заалтыг өөрчлүүлэх шаардлагатай байна.
4. Амьтны тухай хуулийн зарим заалтууд БОАЖС-ын 2012 оны А/299 дугаар тоот тушаалаар батлагдсан журам нь хоорондоо уялдаагүй байна. Үүнд: Шонхор барих зөвшөөрлийг БОАЖС батлахдаа аймагт барих шонхрын

тоог тодорхой болгоогүйгээс орон нутагт сумдын БНАТ орлогыг төлөвлөхөд хүндрэл учруулдаг.

Өөрчлөлт оруулах санал:

1. Төлбөрийн тухай хуулийн 19.1.1 гэсэн заалтыг цуцлах эсвэл ургамлын тухай хуульд ойн дагалт баялгийн талаар тодорхойлолт оруулан бусад ургамлаас салгаж оруулах.
2. Засгийн газрын 02 дугаар тоот тогтоолд хариуцлагын тогтолцоог нэмж оруулах.
3. Улсын хэмжээнд гадаргын болон гүний усны нөөц жил ирэх тусам багасаж байгаатай холбоотойгоор төлбөрийн тухай хуулийн 15.1.1-д заасан хэмжээгээр төлбөр авч түүгээр усны нөөцийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.
4. Ус ашигласны төлбөрийг авч хэвших шаардлагатай тул Төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дэх заалтыг хүчингүй болгох.
5. Сумын байгаль орчин хариуцсан байцаагч нарын ажлын хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах
6. Шонхор барих зөвшөөрлийг аймаг тус бүрээр нь сайдын тушаал гаргаж баталж байх

А.1.2 Аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ногоон хөгжлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

- Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны Ногоон хөгжил бүлгийн арга хэмжээнүүд нь “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байна.
- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хүрээнд 2021 онд төлөвлөгдсөн 10 арга хэмжээний хэрэгжилт 32 хувьтай, 2022 онд төлөвлөгдсөн 10 арга хэмжээний хэрэгжилт 58 хувьтай байна.
- Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2021 онд төлөвлөгдсөн 9 зорилт 12 арга хэмжээний хэрэгжилт 50 хувьтай, 2022 онд 10 зорилт 13 арга хэмжээний хэрэгжилт 54 хувьтай байна.
- Аймгийн 2021-2023 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой 2021 онд төлөвлөгдсөн 1 зорилт 12 арга хэмжээний хэрэгжилт 75 хувьтай, 2022 онд 2 зорилт 13 арга хэмжээний хэрэгжилт 72 хувьтай байна.

Ногоон хөгжлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаа нь хэрэгжих хугацаа дуусаагүй, шаардлагатай санхүүжилтийг аймгийн ИТХ-аас батлаагүй зэрэгтэй холбоотой байна.

А.1.3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой менежментийн төлөвлөгөөг баталсан ч хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбогдуулан ойн 13, усны сав газрын 2, агнуурын менежментийн 5, газар зохион байгуулалтын 23 менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Эдгээр менежментийн төлөвлөгөөний хүрээнд 583 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 66,620.0 сая төгрөгийн улс, орон нутгийн төсвийн хөрөнгө шаардлагатай гэсэн тооцоог гаргасан байна.

2021онд аймаг сумдын Засаг дарга нар байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхээр баталсан төсөв нь менежментийн төлөвлөгөөний хэрэгжилттэй хэрхэн уялдсаныг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 1. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгалийн нөөцийн нэр	ИТХ-аар Батлагдсан БНСАХ зардлын төсөв /сая, төгрөг/	менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоо	менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь
Ойн нөөц	219.0	96	51%
Ан амьтны нөөц	61.8	151	19%
Усны нөөц	32.7	162	40%
Газрын нөөц		2163	23%

Эндээс харахад аймаг, сумдын Засаг дарга нар агнуурын болон газар зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг тухайн шатны ИТХ-аар батлуулах ажлыг хэрэгжүүлдэггүй, аймгийн БОАЖГ-аас жил бүрийн эцэст менежментийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажилладаггүй зэргээс шалтгаалан тухайн төлөвлөгөөнд тусгагдсан ихэнх ажил хэрэгждэггүй, ашиглалтгүй цаасан баримт болон үлдсэн байна. Түүнчлэн аймгийн БОАЖГ, аймгийн ГХБХБГ, усны сав газрын захиргаа, сум дундын ойн ангиуд нь менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахаар сумдын Засаг дарга нартай хамтарч ажиллаагүй, сумдын байгаль хамгаалагч, газрын даамлуудын ажлын төлөвлөлт, хэрэгжилтийг дүгнэн, менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх талаар тодорхой үүрэг чиглэл өгч ажиллаагүй байна.


А.2. Эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, гэрээнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгаж, дүгнэсэн боловч менежментийн төлөвлөгөө, төлбөрийн орлогоос хуульд

заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.

А.2.1. БОАЖС нь аймгийн Засаг дарга, харьяа төсөв захирагчтай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан менежментийн төлөвлөгөө, төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байна.


Байгаль орчин, аялал жуулчлалын сайд нь аймгийн Засаг даргатай 2021 онд №21-11 тоот, 2022 онд №22-11 тоот хамтран ажиллах гэрээ байгуулжээ. 2021-2022 онд 68-61 арга төлөвлөсний 35-29 хувь нь байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой байна. Тайлант онуудад төлөвлөсөн арга хэмжээний тоо буурч хэрэгжилт нь 90-96 хувь болж өссөн ч байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд төлбөрийн орлогын 11-13 хувийг зарцуулсан нь хангалтгүй байна.

График №1. Аймгийн Засаг даргын төлөвлөсөн арга хэмжээ



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын Идэр голын сав газрын захиргаа, Хяргас нуур Завхан голын сав газрын захиргаатай байгуулсан 2021-2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээний 18-31 хувь нь байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцаатай холбоотой байна. Тус арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг батлаагүйгээс шалтгаалан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг дутуу төлөвлөдөг, төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгждэггүй байна.

График №2. Сав газрын захиргааны төлөвлөсөн арга хэмжээ




A.2.2. Аймгийн Засаг даргын сумдын Засаг даргатай байгуулсан гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг харьцангуй бага тусгажээ.

Аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан 2021-2022 онд хэрэгжүүлэх сумдын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээг судалж үзэхэд 6 хувь нь байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцаатай холбоотой байна. Зарим сумдын хувьд БНАТ-ын орлогогүй тул байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг харьцангуй бага төлөвлөж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлсөн байна. Тайлант онуудын сумдын хөгжлийн төлөвлөгөөг харьцуулан судалж үзэхэд Баянхайрхан, Түдэвтэй, Шилүүстэй зэрэг сумдын Засаг дарга ойн арчилгаа цэвэрлэгээ хийх, хөв цөөрөм үүсгэх, хортон шавжтай тэмцэх ажлуудыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн сайн тал ажиглагдлаа.

Аймгийн хэмжээнд байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг Баянтэс, Баянхайрхан, Дөрвөлжин, Идэр, Их-уул, Тэлмэн, Тосонцэнгэл сумдын хөгжлийн төлөвлөгөөний 8-10 хүртэлх хувийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээ эзэлж байна. Байгалийн нөөц баялаг ихтэй сумдын БНАТ-аас төвлөрсөн татварын давсан орлогыг бусад сумдад хуваарилж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

График №3. Төлөвлөсөн арга хэмжээ/ аймгийн дундаж/



Аймгийн Засаг дарга харьяа төсөв захирагчидтай байгуулсан 2021-2022 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд эзлэх байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцаа аймгийн БОАЖГ 37-32 хувьтай, ГХБХБГ 7 хувьтай, Тосонцэнгэл сумын ойн анги 59-28 хувьтай, Түдэвтэй сумын ойн анги 44-36 хувьтай байна.

Аймгийн БОАЖГ нь 2021 он, 2022 оны БНАТ-ын орлогыг зарцуулахдаа аялал жуулчлалын чиглэл, агаарын бохирдол, Их-Уул сумын мэдээллийн төвийн тохижилтын ажил зэрэг зориулалт бус арга хэмжээг төлөвлөж зарцуулсан, төлбөрийн орлогыг төрөл зүйлээр нь зөв төлөвлөж зарцуулаагүй. Өөрөөр хэлбэл амьтнаас орсон орлогыг амьтдыг нөхөн сэргээхэд бус ой, ургамлыг хамгаалахад зарцуулж байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Аймгийн БОАЖГ болон ГХБХБГ-ын ажилтнууд, сумдын байгаль хамгаалагч, газрын даамлуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгахад албан хаагчдын төлөвлөлт, хэрэгжилтэд тавих дотоод хяналт хангалтгүй, ажлын ачаалал жигд биш байна.

Хүснэгт № 2. Төлөвлөгөөний хэрэгжилт

№	Нэр	Аймаг, нийслэлийн Засаг дарга харьяа төсөв захирагч нарын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
---	-----	---

		2021 он				2022 он			
		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан		Дундаж үнэлгээ		Үүнээс байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцааг тусгасан	
		Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
1	Завхан аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	43	97.2	16	99	58	90.1	19	97
2	ГХБХБГ	57	90.4	4	75	90	91.2	7	70
3	Завхан аймгийн Тосонцэнгэл сумын Ойн анги	22	97	13	90	39	97	11	93
4	Завхан аймгийн Түдэвтэй сумын Ойн анги	25	86	11	83	33	91	12	91

БҮЛЭГ Б. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАХ ТӨЛБӨРИЙН ОРЛОГЫН ХЭСГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХЭРЭГЖЭЭГҮЙ БАЙНА.

Б.1. Төлбөрийн орлогын хэсгийн бүрдүүлэлт хуулийн дагуу хэрэгжээгүй байна.

Б.1.1. Ургамал болон зарим амьтдын нөөцийг тогтоогоогүй байхад ашиглах дээд хэмжээг баталсан зөрчил илэрлээ.

Аймгийн хэмжээнд нэн ховор ургамал 38 зүйл, ховор ургамал 134 зүйл, элбэг ургамал 621 зүйл ургадаг байна. БОАЖС-ын 2021 оны А/136 дугаар тушаалаар элбэг ургамлаас 6 төрөл зүйл, 2022 оны А-190 дугаар тушаалаар ховор ургамлаас 1 төрөл зүйл, элбэг ургамлаас 8 төрөл зүйлийг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, ашиглах дээд хэмжээг тогтоосон байна.




Аймгийн хэмжээнд 48 зүйлийн амьтнаас 46 зүйл амьтны нөөцийг тогтоож, шонхор шувуу, загасны нөөцийг тогтоогоогүй байна. Загасны нөөцийг тогтоогоогүй мөртөө 2021 онд 200 ширхэг, 2022 онд 150 ширхэг загас барих дээд хэмжээг БОАЖС-ын тушаалаар зөвшөөрсөн нь амьтны тухай хуулийн 5.8.1-д “Батлагдсан ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан агнуурын нөөцөд тулгуурлан жил бүр ашиглах агнуурын амьтны төрөл, тоо хэмжээний талаар санал боловсруулж, төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэх” гэх



заалтыг зөрчсөн байна.

График №4. Амьтныг ашиглах дээд хэмжээ



2021-2023 онд тусгай зориулалтаар Аргаль, Янгир, Халиун буга, ахуйн зориулалтаар бор гөрөөс, зэрлэг гахай, загас, саарал чоно агнаж, барихыг зөвшөөрсөн байна.



Шонхор шувууны нөөц тогтоогоогүй байхад 2021 онд 14 аймаг, 2022 онд 17 аймагт агнах зөвшөөрлийг БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга олгосон байна. Тухайн аймгийн нөөцийг тооцож, ашиглах дээд хэмжээг тогтоохгүйгээр агнах зөвшөөрөл олгосон нь шонхор шувуу дайжих, устгах, төлбөрийн орлогыг зориулалт бус зарцуулах сөрөг үр дагавар үүсэж байна.

Аймгийн хэмжээнд шинэс, бургас, гацуур, нарс, улиас зэрэг 6 төрөл зүйлийн модны нөөц тогтоож 2021 онд 4 төрөл зүйл, 2022 он, 2023 онд 3 төрөл зүйл модны ашиглах дээд хэмжээг тогтоосон байна.

Ус, рашааны нөөц тогтоох ажлыг жил бүр хийдэггүй мэргэжлийн эрх бүхий байгууллагын томоохон судалгааны ажлын үндсэн дээр хийдэг бөгөөд 4.3 сая м3 усны нөөцийг тогтоож, гадаргын уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг 0.20 сая м3, газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг 0.37 сая м3-ээр тогтоосон байна. Түүнчлэн Алдархаан сумын “Богдын голын” УЦС, Дөрвөлжин сумын “Баян-Айраг” ХХК, Завханмандал, Ургамал сумдын “Шувуун хар уул” ХХК, Отгон сумын Хужиртын голын хэсэг, Цагаанчулуут сумын Гүүтийн булгийн эх, Улиастай сумын богдын голын гүүрний дээд хэсэг, Алдархаан сумын Отгонтэнгэрийн рашаан сувиллын үйл ажиллагаанд ашиглах усны боломжит нөөцийн дүгнэлтийг гаргасан байна.

Б.1.2.Төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх харилцааг журмын дагуу хэрэгжүүлсэн байдал 70 хувьтай байна.

- Аймгийн Засаг дарга нутаг дэвсгэртээ холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиглах ургамал, ан амьтан, ойн нөөцийн төрөл, дээд хэмжээний талаарх саналаа жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.
- Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.2-т заасан саналыг хянан, ашиглах байгалийн нөөцийн төрөл, дээд хэмжээг тогтоож, жил бүрийн 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргад хүргүүлсэн. Харин 2023 оны үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, ашиглах ургамлын ашиглах дээд хэмжээг одоо болтол тогтоогоогүй, хугацаа хоцорч байна.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг журамд заасан хугацаанд сум бүрээр тогтоосон. Харин 2021 онд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг мөн оны 08 дугаар сарын 17-нд, 2022 онд ахуйн зориулалттай агнах, барих амьтан, үйлдвэрийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хязгаарыг мөн оны 11 дүгээр сарын 18-нд сум бүрээр тогтоож журамд заасан хугацааг хоцроосон байна. Түүнчлэн 2022 онд тусгай төлбөртэй агнах, барих амьтны дээд хязгаарыг сум бүрээр тогтоогоогүй байна.
- Сум, дүүргийн Засаг дарга нар нь Төсвийн тухай хуулийн 23.8.4, 23.8.6, 23.8.7, 23.8.9, 23.8.14-т заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-1 маягтын дагуу жил бүрийн 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ гэснийг мөрдөөгүй, 2023 оны 1 сард Байгаль орчны яамны цахим системд нөхөн оруулсан байна.
- Аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасан орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-3 маягтын дагуу жил бүрийн 7 дугаар сарын 25-ны өдрийн дотор боловсруулсан.
- Аймгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага энэ журмын 2.5, 2.6-д заасан нийт орлогын төлөвлөгөөг энэ журмын хавсралт БНАТ-5 маягтын дагуу нэгтгэж, аймаг, нийслэлийн төсвийн саналд тусгуулахаар жил бүрийн 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор тухайн шатны Засаг даргад хүргүүлсэн байна.

Б.1.3. Байгалийн ургамал, ан амьтан, ойн нөөцийг ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон, үйлдвэрлэл үйлчилгээний болон рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалттай усыг зөвшөөрөлгүй ашигласан байна.

- ✓ 2021-2023 онд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар ус ашигласан 15 сумын 95 иргэн, аж ахуйн нэгж байгууллага, Цэцүүх, Зарт, Баянзүрх, Улаан-хаалга,

Хожуулын голын рашаан ашигладаг 5 аж ахуйн нэгж байгууллага нь зөвшөөрөл авалгүйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

- ✓ Элбэг ургамлын тухайд жилдээ 16.0-17.0 мянган килограмм жимс түүх зөвшөөрөл олгодог боловч ашигласан хэмжээнд хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.

Хүснэгт №3 Байгалийн ургамал түүх зөвшөөрөл олгосон судалгаа

№	Нэр	Байгалийн ургамал түүх зөвшөөрөл олгосон хэмжээ.				
		Олгосон огноо	Нэн ховор	Ховор ургамал	Элбэг ургамал	хэмжих нэгж
1	Алдархаан	2021			2950	кг
		2022			2750	кг
2	Их-Уул	2021		1	5500	кг
		2022			6200	кг
3	Идэр	2021			200	кг
		2022			200	кг
4	Тосонцэнгэл	2021		1	7000	кг
		2022			7800	кг
5	Тэлмэн	2021			300	кг
		2022			200	кг
6	Тэс	2021			200	кг
		2022			200	кг
Дүн		2021			16150	
		2022		2	17350	

15 сумын байгаль орчны байцаагч нар 2021-2022 онд 96 иргэн, аж ахуйн нэгжийн зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэсэн зөрчлийг илрүүлэн аймгийн Экологийн цагдаагийн алба, Прокурорын байгууллагад шилжүүлэн шалгуулжээ. 2023 оны 06 сарын байдлаар 51 зөрчлийн хэрэг эцэслэн шийдвэрлэгдэж, 45 хэрэг мөрдөн шалгах ажиллагааны шатандаа байна.

Б.1.4 Шонхороос бусад ан амьтны нөөц ашигласны төлбөрийг үндэслэлгүй төлөвлөсөн байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн гүйцэтгэл төлөвлөгөөнөөс 2021 онд 1,524.7 сая төгрөгөөр, 2022 онд 1,755.7 сая төгрөгөөр тус тус давсан үзүүлэлттэй байна. Энэ нь төлөвлөгөөгүйгээр 2021 онд шонхор шувуу барих төлбөрөөс 1,1760.0 сая төгрөгийн, 2022 онд 1,529.0 сая төгрөгийн орлого төвлөрсөнтэй холбоотой байна.

Бусад ан амьтны төлбөрийн орлогыг аймгийн татварын хэлтэс төлөвлөхдөө өмнөх онуудын гүйцэтгэлд үндэслээгүй, 244.6 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

Хүснэгт №4 БНАТ гүйцэтгэл, төлөвлөлт

Төрөл	2021 он			2022 он		
	төл	гүйц	зөрүү	төл	гүйц	зөрүү

Ойн нөөц ашигласны төлбөр	284.9	382.1	(97.2)	460.0	363.9	96.1
Байгалийн ургамал ашигласны төлбөр	7.0	10.7	(3.7)	13.2	5.8	7.4
Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөр	290.0	134.6	155.4	320.0	286.4	33.6
Унд ахуйн зориулалттай усны нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	1,350.8	(1,350.8)	10.0	1,863.4	(1,853.4)
Газрын төлбөр	345.0	573.4	(228.4)	560.0	599.4	(39.4)
Нийт байгалийн нөөц ашигласны төлбөр	926.9	2,451.6	(1,524.7)	1,363.2	3,118.9	(1,755.7)

2021-2022 оны ойн нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг аудитаар шалгахад зөрчил илрээгүй, байгалийн ургамал ашигласны төлбөрийн ногдуулалт нь татварын ногдуулалтаас 8.3 сая төгрөгөөр дутуу байгаа нь ойн нөөцийн төлбөр дээр ойн дагалт баялгийн төлбөрийг нэмж тооцдогтой холбоотой байна.

Хүснэгт №5 Төлбөрийн судалгаа

Татварын төрөл	Ойн нөөц ашигласны төлбөр		Байгалийн ургамал ашигласны төлбөр		Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөр		Ан амьтны нөөц ашигласны төлбөр	
	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
Он	2021	2022	2021	2022	2021	2022	2021	2022
Аудитын ногдуулалтаар	386.6	361.8	2.5	4.7	586.3	691.3	1,323.7	1,675.8
Татварын ногдуулалтаар	386.6	361.7	7.7	7.9	134.5	287.3	1,435.1	1,863.4
Зөрүү /Ногдуулалт/	0.0	(0.1)	5.2	3.2	(451.8)	(404.0)	111.4	187.6
Төрийн сангийн хуулгаар	382.1	363.9	10.7	5.8	134.6	286.3	1,405.7	1,863.3
Зөрүү /Гүйцэтгэл/	(4.51)	2.2	8.3	1.0	(451.7)	(404.9)	54.9	187.6

Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөрийг 25 иргэн, аж ахуйн нэгжээс авахаар тооцоход 2021-2022 онд 1,277.6 сая төгрөгийн ногдуулалт тооцогдсон нь татварын ногдуулалтаас 855.8 сая төгрөгөөр илүү байна. Энэ нь 2021-2022 онд “Баян айраг Эксплорэйшн” ХХК-д үйлдвэрлэлийн осол гарсан, ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа нь тодорхой хугацаанд зогссон зэргээс шалтгаалан технологийн усны ашиглалт буурсантай холбоотой байна. Тус компанийн ашигласан усны хэмжээнд Дөрвөлжин сумын байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нар тоолуурын заалтыг үндэслэн хяналт тавьдаг байна.

Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн 2021-2022 оны ногдуулалт нь татварын ногдуулалтаас 299.0 сая төгрөгөөр дутуу байна.

2021-2022 оны аудитын ногдуулалтаас ойн нөөц ашигласны төлбөр орлогоос 2.3 сая төгрөгөөр дутуу, байгалийн ургамал ашигласны төлбөр 9.3 сая төгрөгөөр илүү, үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай усны нөөц ашигласны төлбөр 856.6 сая төгрөгөөр дутуу, ан амьтны нөөц ашигласны төлбөр 242.5 сая төгрөгөөр илүү төвлөрсөн байна.

Б.2. Төлбөрийн орлогын хэсгийн зарцуулалт хуулийн дагуу хэрэгжээгүй байна.

Б.2.1. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөөгүй, 164.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 17 арга хэмжээг зарцуулахаар төлөвлөж батлуулсан байна.

Аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нар нь 2021-2023 онд төлбөрийн орлогоос 768.6 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөгүй нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

Хүснэгт №6 Орлого, зарцуулалт

Он	Орлогын төлөвлөгөө			Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд				
	өмнөх оны давсан орлого	тайлант оны төлөвлөгөө	Нийт орлого	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	ИТХ-ын баталсан зардал	төлбөрийн орлогын эзлэх хувь	хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Менежментийн төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний тоо
2021	391.2	926.9	1318.1	441.2	450.7	34	40	30
2022	1680.1	1363.2	3043.3	1346.6	713.3	23	43	36
2023	1892.8	976.9	2869.7	1305.6	1160.9	40	32	32

2021 онд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх 40 арга хэмжээнд 450.7 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 72.5 сая төгрөгийн 10 арга хэмжээний зардал нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

2022 онд байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх 43 арга хэмжээнд 713.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс 92.3 сая төгрөгийн 7 арга хэмжээний зардал нь менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Б.2.2. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулаагүй, батлагдсан төсвийн 16.4 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Аймаг, сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нар нь 2021-2022 онд төлбөрийн орлогоос 2,567.8 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

2021-2023 онд төлбөрийн орлогоос 791.4 сая төгрөгийг байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулан, 167.6 сая төгрөгийг Баянхайрхан, Дөрвөлжин, Идэр, Их-Уул, Түдэвтэй, Шилүүстэй, Эрдэнэхайрхан сумдын Засаг дарга, аймгийн БОАЖГ нь зориулалт бусаар зарцуулсан байна.

Хүснэгт №7 Гүйцэтгэл

Он	Орлогын гүйцэтгэл			Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд							
	өмнөх оны давсан орлого	төсөвт төвлөрүүлсэн орлого	Нийт орлого	Хуулийн дагуу зарцуулбал зохих доод хэмжээ	Зарцуулсан зардал	төлбөрийн орлогын эзлэх хувь	хэрэгжүүлсэн арга хэмжээ	төлөвлөгөөнд		төсвийн зарцуулалт	
								тусгасан арга хэмжээ	Тусгаагүй арга хэмжээ	Зориулалтын дагуу	Зориулалт бус
2021	391.2	2,451.5	2,842.7	1,301.4	327	11%	40	30	10	254.3	73.2
2022	1,680.1	3,118.9	4,799.0	2,224.9	631.5	13%	43	36	7	537.1	94.4
2023	1,892.8	285.7	2,178.5	1,062.1	67.8	3%	6	6	0	57.8	0

БҮЛЭГ В.1. БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙГЭЭГҮЙ, НӨХЦӨЛ БАЙДАЛД ТОХИРОХ АРГА ХЭМЖЭЭ АВААГҮЙ БАЙНА.

В.1. Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан үнэн зөв илэрхийлэгдээгүй, төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангалтгүй байна.

В.1.1 Хуулийн хэрэгжилтийн тайлагнал, мэдээллийн сан бүрдүүлэлт, ил тод байдал хангагдаагүй байна.

Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын”-ын дагуу www.eic.mn/finance/ веб сайтад байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын 2022 оны мэдээллийг 2023 оны 1-р сард нөхөн бүртгэсэн байна.

Ингэхдээ 22 сум мэдээллийг бодит байдлаас доорх байдлаар зөрүүтэй тайлагнаж, Асгат, Ургамал сумдын Засаг дарга нар байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийг оруулаагүй байна.

Мэдээллийн зөрүү				
БНАТ-ийн орлогын төлөвлөгөө	БНАТ-ын орлогын гүйцэтгэл	Давсан орлого	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төлөвлөгөө	Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын гүйцэтгэл
333.48	1763.16	-1429.68	-281.805	-439.7

www.eic.mn/finance/ веб сайтад байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг 66 хувьтай гэж тайлагнасан нь бодит байдлаас 45.6 хувиар илүү байна.

Сумдын байгаль хамгаалагч, байгаль орчны байцаагч, БОАЖЯ-ны eic.mn/finance/ систем хариуцсан мэргэжилтнүүд харилцан мэдээлэл солилцдоггүй, программ ашиглалт хангалтгүй, www.eic.mn веб сайтын ил тод байдал бүрэн хангагдаагүй байна.

В.1.2 Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоо үр дүнгүй байна.

Байгаль орчин аялал жуулчлалын газар нь байгаль орчинтой холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлүүлэхээр аймгийн ИТХ-д санал хүргүүлдэг

боловч дэмждэггүй, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэж өгдөггүйгээс тус салбарт хийгдэхээр төлөвлөгдсөн ажлууд бодит үр дүнд хүрч чадахгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, www.eic.mn веб сайтын мэдээлэл дараах байдлаар зөрүүтэй, тус байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа хангалтгүй байна гэж дүгнэлээ.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын гүйцэтгэл			Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын гүйцэтгэл	
Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Татварын газрын мэдээгээр орлогын гүйцэтгэлийн дүн	Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд орлогын гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн	Аймаг, нийслэлийн санхүү, төрийн сангийн зарцуулалтын гүйцэтгэлийн дүн	Аймаг, нийслэлийн БОАЖГ-аас eic.mn/finance/ системд зарцуулсан гүйцэтгэлийн мэдээг оруулсан дүн
4982.3	4384.3	1355.74	634.1	1073.8

В.2. Хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээг хийж үр дүнг тооцоогүй байна.

В.2.1. Аймгийн байгаль орчны газар нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шинжилгээ хийж үр дагаврыг үнэлээгүй байна.

- ✚ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгасан эсэхэд үр дагаврын үнэлгээ хийгээгүй
- ✚ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлсон эсэхэд үр дагаврын үнэлгээг хийгээгүй
- ✚ Зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлсон эсэхэд үр дагаврын үнэлгээ хийгээгүй

В.2.2. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, үр дүнг тооцоогүй байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд 2021-2023 онуудад хяналт хийгээгүй байна.

14 сумын ИТХ-аас 2021-2023 онуудад 51 удаагийн хяналтыг хийсэн гэсэн судалгааг ирүүлсэн боловч хяналтын тайлангаа Аймгийн иргэдийн хурлын ажлын

албанд ирүүлээгүй байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т “Хяналт шалгалтыг төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага /цаашид “хяналт шалгалтын байгууллага” гэх/ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хийх бөгөөд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн гэж ангилна” Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1-т “Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ” Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.7-д “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулна” гэсэн заалтуудыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитаар нийт 7,979.7 сая төгрөгийн зөрчил илрүүлэн, 167.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 7,812.1 сая төгрөгийн зөрчилд 15 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль нь 4 хууль тогтоомж, бусад эрх зүйн 2 актын зүйл заалттай нийцээгүй байна.
2. Аймгийн хөгжлийн бодлогын урт, дунд болон богино хугацааны баримт бичигт тусгагдсан ногоон хөгжлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.
3. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой менежментийн төлөвлөгөөг баталсан ч хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулаагүй, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй байна.
4. Аймгийн Засаг дарга сумдын Засаг даргатай байгуулсан 2021-2022 онд хэрэгжүүлэх сумдын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээг судалж үзэхэд 6 хувь нь байгалийн нөөц ашигласны төлбөр, түүнтэй холбогдох харилцаатай холбоотой байна.
5. Ургамал болон зарим амьтдын нөөцийг тогтоогоогүй байхад ашиглах дээд хэмжээг баталсан зөрчил илэрлээ.
6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь ойгоос бэлтгэх модны дээд хязгаарыг журамд заасан хугацаанд сум бүрээр тогтоосон. Харин 2021 онд агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг мөн оны 08 дугаар сарын 17-нд, 2022 онд ахуйн зориулалттай агнах, барих амьтан, үйлдвэрийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын дээд хязгаарыг мөн оны 11 дүгээр сарын 18-нд сум бүрээр тогтоож журамд заасан хугацааг хоцроосон байна. Түүнчлэн 2022 онд тусгай төлбөртэй агнах, барих амьтны дээд хязгаарыг сум бүрээр тогтоогоогүй байна.
7. Байгалийн ургамал, ан амьтан, ойн нөөцийг ашиглах зөвшөөрлийг хууль тогтоомжийн дагуу олгосон, үйлдвэрлэл үйлчилгээний болон рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалттай усыг зөвшөөрөлгүй ашигласан байна.
8. Шонхороос бусад ан амьтны нөөц ашигласны төлбөрийг үндэслэлгүй төлөвлөжээ.
9. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөөгүй, 172.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 21 арга хэмжээг зарцуулахаар төлөвлөж батлуулсан байна.
10. Төлбөрийн орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулаагүй, батлагдсан төсвийн 16.4 хувийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.
11. www.eic.mn цахим системд 22 сумын Засаг дарга мэдээллийг бодит байдлаас зөрүүтэй тайлагнаж, Асгат, Ургамал сумдын Засаг дарга нар байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийг оруулаагүй байна.
12. Аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс, аймгийн Татварын хэлтэс, www.eic.mn веб сайтын мэдээлэл зөрсөн, тус байгууллагуудын хоорондын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагаа хангалтгүй байна.

13. Аймгийн байгаль орчны газар нь байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шинжилгээ хийж үр дагаврыг үнэлээгүй байна.
14. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хуулийн хэрэгжилтэд хяналт хийж, үр дүнг тооцоогүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг байна.

Аймгийн ИТХ-ын дарга Н.Тамирт:

1. Монгол улсын Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолд заасан хугацааг баримтлан аймагт үйлдвэрийн зориулалтаар түүж бэлтгэх ургамлын болон агнах, барих амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг батлах,
2. Тухайн жилд аймгийн хэмжээнд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний дээд хязгаарыг батлахдаа тухайн амьтны нөөц, тухайн агнуурын бүсийн менежментийн төлөвлөгөө зэрэгт үндэслэх
3. Төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг батлахдаа “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хуульд заасан хувь хэмжээг баримтлах
4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцох үүргийг сумдын ИТХ-ын дарга нартаа өгч биелэлтийг тооцох

Аймгийн Засаг дарга Г.Өнөрбаярт:

1. Аймгийн хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны баримт бичигт тусгагдсан ногоон хөгжлийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх, шаардлагатай байгаа санхүүжилтийг аймгийн ИТХ-аар батлуулах
2. Үйлдвэрлэл үйлчилгээний болон рашаан-эмчилгээ, сувилгааны зориулалттай усыг зөвшөөрөлгүй ашигласан зөрчлийг арилгах үүргийг холбогдох байгууллагуудад өгч биелэлтийг тооцох
3. Сумдын Засаг дарга, харьяа байгууллагуудын удирдлагатай байгуулсан хамтран ажиллах гэрээг 2023 оны эхний хагас жилийн байдлаар дүгнэхдээ сумдын хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан ногоон хөгжлийн зорилт, арга хэмжээ, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах, үнэн зөв тайлагнах үүрэг өгч биелэлтийг тооцох

4. Төлбөрийн орлогыг байгаль нөхөн сэргээх, хамгаалах арга хэмжээнд зориулалтын дагуу зарцуулах үүргийг сумдын Засаг дарга, аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт өгч, биелэлтийг тооцох

Аймгийн БОАЖГ-ын дарга Б.Мөнхбат-д:

1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээхтэй холбоотой менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулах, биелэлтэд хяналт тавьж ажиллах
2. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн гол орлого бүрдүүлж буй ургамал, загас, шонхор шувууны нөөцийг тогтоолгох судалгааны ажлын төсвийг хийн, зардлыг аймгийн ИТХ-аар батлуулж хэрэгжүүлэх
3. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилт, төлбөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шинжилгээ хийж, үр дагаврыг үнэлэх
4. Аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэстэй хамтран www.eis.mn цахим хуудас дээр байршсан байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн зөрүүг арилгах ажлыг зохион байгуулах
5. Төлбөрийн орлогыг хуульд заасан хувь хэмжээний дагуу төлөвлөж, зарцуулах, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөхдөө менежментийн төлөвлөгөөтэй уялдуулах,

Аймгийн ГХБХГ-ын дарга Д.Анхтэс-д:

1. Сумдын газрын даамлуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгч, аудитаар илэрсэн зөрчлийг арилгах

Аймгийн Татварын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Пүрэвжаргалд

1. 2024 оны аймгийн төсвийн орлогыг төсөөлөлд шонхроос бусад ан амьтны нөөц ашигласны төлбөрийг үндэслэлтэй төлөвлөх

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: №01



2023.06.27 № 187
танай _____ -ны № _____ т

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Т. Завхан
Аудирын газраар
Тусгай
[Signature]

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 1303/584 дугаар тоот албан тоотын хариуг хүргүүлж, нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах саналуудыг хүргүүлж байна.

1. Б.1.1 Завхан аймагт нэн ховор ургамал байхгүй гэж тусгасан байна.

Аймгийн ЗДТГ-ын санхүүжилтээр ШУА-ийн ерөнхий болон сорилын биологийн хүрээлэн 2017 онд Завхан аймгийн ургамлын аймаг, ургамалжилт, бэлчээр нэртэй судалгаа хийсэн бөгөөд тус судалгаагаар Завхан аймагт 77 овог 316 төрөлд хамаарах 793 зүйл ургамал бүртгэгдсэн. Ургамлын аймгийн нийт зүйлийн бүрдлийн дотор нэн ховор 38 зүйл, ховор 9 зүйл/ үүнээс олон байх боломжтой/ унаган 59 зүйл, эмийн 168 зүйл, хүнсний ургамал 68 зүйл тус тус бүртгэгдсэн ба тухайн ургамлын судалгаа нь зөвхөн зүйл тогтоох судалгаа бөгөөд ашиглах нөөц, даацын судалгаа хийгдээгүй байна.

2. Б.1.4 Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашиглах усны нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтанд "Баян айраг" ХХК-ны 2021 оны Ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур Завхан голын сав газрын захиргааны 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/07 дугаартай ус ашиглуулах зөвшөөрөл, 03 дугаартай ус ашиглуулах гэрээнд Ус ашигласны төлбөр нийт 552,686,086 төгрөгийн гэрээ байгуулсан байгуулснаас "Баян-Айраг" ХХК нь 2021 онд 116,899,273 төгрөг төвлөрүүлсэн аймгийн хэмжээнд 2021 оны татварын төлөвлөгөөнд 290,000,000 төгрөг төлөвлөснөөс 134,478,000 төгрөг төвлөрүүлж, 155,524,000 төгрөг тасарсан байна.

2022 онд "Баян-Айраг" ХХК нь 2022 оны Ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур Завхан голын сав газрын захиргааны 2022 оны 04 дугаар сарын 04-ны өдрийн А/08 дугаартай ус ашиглуулах зөвшөөрөл, 01 дугаартай ус ашиглуулах гэрээнд Ус ашигласны төлбөр нийт 662,882,388.24 төгрөгийн гэрээ байгуулсан байгуулснаас "Баян-Айраг" ХХК нь 2022 онд 246,201,776 төгрөг төвлөрүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2022 онд усны нөөц ашигласны төлбөрийн татварын орлогын төлөвлөгөөнд 320,000,000 төгрөг төлөвлөснөөс 287,325,000 төгрөг төвлөрүүлж, 32,675,000 төгрөг тасарсан байна. Баримтыг хавсаргав.

ДАРГА [Signature] Б.МӨНХБАТ



Тоот А4

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ: №02


**ЗАВХАН АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**
 81090 Улиастай, Завхан аймаг
 Утас/Факс: 7046-2434
 И-мэйл: zavkhanboajg@gmail.com

2023.06.27 № 190
 танай _____ -ны № _____ т

Санал хүргүүлэх тухай

ЗАВХАН АЙМГИЙН ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Г. Баянз

Аудилогч санал

тусгай

Баянз

Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Усны газраас гаргасан ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэж ХНЗГСГЗ-ны ус ашиглуулах тушаал, гэрээгээр ус ашиглах эрх үүсдэг. "Баян Айраг Эксплорэйшн" ХХК нь ус ашиглалтын 3-н худгийн тоолуурын заалтыг Эрдэнэхайрхан сумын БОХУБ, байгаль хамгаалагч нар, Шүүрлийн усны тоолуурыг Дөрвөлжин сумын БОХУБ, байгаль хамгаалагч нар хянаж ашигласан усны тоолуурыг заалтаар бодож төлбөрийг төсөвт төвлөрүүлдэг. Мөн "Баян Айраг Эксплорэйшн" ХХК нь 2021-2022 онд боловсруулах үйлдвэрт үйлдвэрлэлийн осол гарсан мөн ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагааг зогсоосон тул уурхай ажиллаагүй үед технологийн усны төлбөр гараагүй нь төлөвлөсөн орлогын төлбөр тасарсан байна.

Мөн дээр онуудад ковид-19 цар тахал, хөл хорионы улмаас ус ашиглагч аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаа зогссон, хэвийн ажиллах нөхцөл алдагдсантай холбоотой ус ашигласны төлбөрийн орлого буурсан үзүүлэлттэй байна.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөөг сүүлийн жилүүдийн дундаж болон томоохон ус ашиглагч үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэж төлөвлөдөг. Тухайн жилийн төлөвлөгөөнд орлого тасрах болон давах болон эрсдэлийг урьдчилан тооцоолон орлогыг төлөвлөх боломжгүй байдаг тул дээрх аудитын тайлангийн Б.1.4-д заасан дутуу төлөгдсөн 855,6 сая төгрөгийн зөрчлийг ариулгуулах албан шаардлага хүргүүлэхтэй санал нийлэхгүй байна.

ДАРГА  Б. МОНХБАТ



ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР:

Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас 2 асуудалд тайлбар санал ирүүлснийг удирдлагын зөвлөлөөр хэлэлцээд Б.1.1 асуудлыг тайлан судалгаанд залруулж, Б.1.4 асуудлын нотлох баримтыг үндэслэн албан шаардлага хүргүүлэхээс хасаж тайлан нэмэлт тайлбар оруулахаар шийдвэр гаргалаа.

Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн 1 тайлбар 1 саналын үндэслэлийг аудитаар хүлээн зөвшөөрч тайланд өөрчлөлт орууллаа.



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 1301/А/181

Улиастай

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан "Эрх шилжүүлэх" тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2020 оны А/106 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх заалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1."Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Говь-Алтай аймаг дахь төрийн аудитын газар, Завхан аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Н.Тамир, Засаг дарга Г.Өнөрбаяр, Байгаль орчин аялал жуулчлалын газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор (Г.Заяа)-д даалгасугай.

3.Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг Байгаль орчин аялал жуулчлалын газар (Б.Мөнхбат)-д зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор (Г.Заяа), аудитор (Б.Мөнхнасан, Г.Баасанжаргал, Т.Баасанжаргал) нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

013010372